



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn,
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.02.28 № 02/423


танай _____-ны № _____-г

Тайлан хүргүүлэх тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн 2022 оны жилийн эцсийн биелэлтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн үүгээр хүргүүлж байна.

Хавсралт.9 хуудастай.

ДЭД САЙД



Ж.ЭРХЭМБААТАР



ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

“Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн биелэлтийн тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн биелэлтийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн талаар:

Хурлыг 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 10 цагаас тус яамны “Хурлын танхим”-д эхлүүлж, Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Батцэцэг удирдан явуулав.

Хуралд:

1. Б.Билэгдэмбэрэл /Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/
2. Э.Насанбат /Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/
3. Л.Нямдорж /Хуулийн хэлтсийн дарга/
4. Б.Золбоо /Цахим засаглалын хэлтэс/
5. Б.Энх-Амгалан /Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга/
6. Ц.Гантөгс /Сансарын холбооны хэлтсийн дарга/
7. Д. Батбаяр /Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга/
8. П.Дэлгэрмаа /Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга/
9. Д.Ариунзул /Хүний нөөцийн бодлого хариуцсан шинжээч/-д нар оролцов.

Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн А.Түвшинзаяа, мэргэжилтэн Д.Цэрэнпүрэв нар оролцов.

Хэлэлцсэн асуудал:

Тус яамны “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-т тусгасан 7 үйл ажиллагааны хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах тухай;

СОНССОН нь:

Байгууллагын “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-т тусгасан 7 үйл ажиллагааны хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Түвшинзаяа танилцуулав. /Биелэлтийг хавсаргав/

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг. “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг холбогдох журмын дагуу

1523041469


Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Х.Сүрэнхорол/-т даалгаж шийдвэрлэв.

Хоёр. "Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн биелэлтийн тайланг тогтоосон хугацаанд тухай бүр тайлагнаж хэвшихийг Хүний нөөцийн бодлого хариуцсан шинжээч /Д.Ариунзул/-д нарт үүрэг болгов.

Хурал 10 цаг 50 минутад дуусав.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

2023 оны 22 дугаар сарын 16-ны өдөр



Б.БАТЦЭЦЭГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,

ДОТООД ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН *Д.Цэрэнпүрэв* Д.ЦЭРЭНПҮРЭВ

2023 оны 22 дугаар сарын 16-ны өдөр

Арга хэмжээний төлөвлөгөө
Цахим хөгжил, харилцаа холбооны яам
2022 оны жилийн эцэс

2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх			
1	1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	<p>1.Төрийн захиргааны удирдлагын газраас 2022 оны 10 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд Удирдлагын академаас зохион байгуулсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах танхимын сургалтад яамны бүх албан хаагчдыг хамруулав. Мэдээний линк: https://mddc.gov.mn/mn/10191/. Мөн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Архивын ерөнхий газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ц.Золжаргал тус байгууллагад хүрэлцэн ирж "Албан бичгийн стандарт, боловсруулах арга зүй" сэдвээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, сургалт өгсөн. Тус сургалтаар яамны 45 албан хаагч хамрагдсан.</p> <p>2. Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Үндэсний аудитын газартай хамтран "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийн талаар яамны болон харьяа, салбар байгууллагуудын шилэн дансны мэдээлэл оруулах үүрэг бүхий албан хаагчдад сургалт хийв. Мөн 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Салбарын харьяа 8 байгууллагын 14 санхүүгийн ажилтнуудад Сангийн яам, Үндэсний аудитын газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төлөөлөл, багш нараар Төрийн аудитын хууль тогтоомж, Засгийн газрын нэгтгэсэн тайлан бүртгэл, Төрийн өмчийн хөрөнгийн тооллого, хөдөлгөөний талаар сургалтад хамруулсан.</p> <p>3.Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газрын албан хаагчидтай хамтран "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай" танин мэдэхүйн мэдлэг, мэдээлэл өгөх сургалт зохион байгуулав. Мэдээний линк: https://mddc.gov.mn/mn/11334/</p> <p>4.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр "Эрсдэлд суурилсан дотоод аудит" сургалтыг Санхүү эдийн засгийн их сургуультай хамтран салбарын хэмжээний байгууллагуудын дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ, нягтлан бодогч нийт 24 албан хаагчдыг хамруулав. Мэдээний линк: https://mddc.gov.mn/mn/10903/ Хавсралт : 4 зураг</p>	100%
2	2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	<p>1.Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг 7:4:10 арга зүйн сургалтад цахим хэлбэрээр нийт албан хаагчид хамрагдсан. Мэдээний линк: https://csc.gov.mn/b/77/70</p> <p>2.Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас яамны албан хаагчдад "Кибер аюулгүй байдлын суурь ойлголт болон нийтлэг тохиолддог халдлагаас өөрийгөө хэрхэн хамгаалах, зөрчилд үзүүлэх хариу арга хэмжээний талаар" мэдлэг ойлголт өгөх танхимын сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр 09:00-12:00 цагийн хооронд зохион байгуулсан. Нийт 25 албан хаагч хамрагдсан.</p> <p>3.Бодлого, төлөвлөлтийн газраас "Жендэрийн тэгш байдлыг хангах, ойлголт" сэдэвт сургалтыг яамны нийт албан хаагчдад болон харьяа, салбар байгууллагын албан хаагчдыг хамруулан цахим болон танхимын сургалтыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр нийт 50 албан хаагчийг хамран зохион байгуулсан. Мэдээний линк: https://mddc.gov.mn/mn/5465/ Мөн тус газраас "Стресс менежмент" сэдэвт сургалтыг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран яам болон харьяа, салбар байгууллагын 107 албан хаагчдыг оролцуулан танхимаар болон цахимаар зохион байгуулсан.</p> <p>4.Архивын ерөнхий газрын зохион байгуулдаг архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтад тус яамны архив-бичиг хэргийн мэргэжилтнээр ажиллаж байгаа 2 албан хаагчийг хамруулсан. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн суурь мэдлэг олгох худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх эрх олгох сургалтад 2 албан хаагчийг тус тус хамруулсан.</p> <p>5. Эдийн засаг хөгжлийн яамны "Үр дүнд суурилсан арга зүйгээр Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах нь" сэдэвт сургалтад 3 албан хаагчийг хамруулсан. Мэдээний линк: http://med.gov.mn/post/125397 Хавсралт : 2 файл</p>	100%

3	3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	<p>1. Албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхийг сайжруулах зорилгоор тус яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын албан хаагчдыг "Бодлого тодорхойлох, судалгаа, стандарт" сэдэвт сургалтад хамруулсан. Төрийн нарийн бичгийн даргын А106 дугаар тушаалаар 5,500,000 төгрөгийн зардлаар зохион байгуулав.</p> <p>2. Байгууллагын захиалгаар 6 хүртэл сарын хугацаатайгаар гадаадын сургуульд мэргэжил дээшлүүлэх зорилгоор суралцсан 2 албан хаагчид суралцах хугацаанд ажлаас чөлөөлж мөн хугацааны цалинг тооцож олгосон.</p> <p>3. Зайнаас болон цахимаар ажиллах хүсэлт гаргасан 1 албан хаагчтай 6 сарын хугацаатай гэрээ байгуулан цахим хэлбэрээр ажиллуулж, цалин хөлсийг тооцож олгосон.</p> <p>4. Удирдлагын академийн мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдыг ажлын цагаас чөлөөлж, цалин хөлсийг тооцож олгосон.</p>	100%
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах			
4	4. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	<p>1. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар "Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр"-ийг баталсан.</p> <p>2. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн А/23 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам" баталсан бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 118 дугаар тушаалаар журамд нэмэлт, өөрчлөлт оруулж ажилчдын нийгмийн баталгаа хангах чиглэлээр зохицуулалт нэмж тусгасан.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/148 дугаар тушаалаар албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж нийт 93,890,935 төгрөгийн зардлаар урамшуулал олгосон.</p> <p>-Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний хийсэн ажлыг үнэлэн 1 удаа урамшуулал олгосон.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/152 дугаар тушаалаар үр бүтээлтэй ажилласан албан хаагчдад 19,800,000 төгрөгийн мөнгөн шагналын олгосон.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А136, А147 дугаар тушаалаар албан ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажилласан албан хаагчдад 3,277,898 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны Б/170 дугаар тушаалаар ажлын шаардлагаар ээлжийн амралтаа биечлэн эдлээгүй албан хаагчид үндсэн цалингийн 1.5 дахин нэмэгдүүлж, нийт 20,145,883 төгрөгийн нэмэгдэл урамшуулал олгосон.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны Б/139 дүгээр тушаалаар төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлд ажиллаж буй 2 албан хаагчийн үндсэн цалинг нэмэгдүүлэн тогтоосон.</p> <p>-Сэлгэн ажиллаж буй 1 албан хаагчид цолны нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгосон.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны Б/148 дүгээр тушаалаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр 2 албан хаагчид, мөн 3 албан хаагчийн нэмэгдлийг тус тус ахиулан олгосон.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны Б/150 дугаар тушаалаар хууль тогтоомж хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хүрээнд төрийн захиргааны 8 албан хаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг хасаж тооцсон.</p> <p>Хавсралт : 3 файл</p>	100%
5	5. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	<p>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Үүнтэй холбоотойгоор яамны орон тоо, бүтцийн нэгж өргөжсөн. Тодруулбал, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 45 албан хаагчийн орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байсан бол Цахим хөгжил харилцаа холбооны яам нь 90 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхээр болсон. Иймд яамны албан хаагчдын ажлын бүтээмж, ажиллах нөхцөлийг сайжруулах, шинээр бий болсон нэгжүүдийн албан хаагчдын ажлын өрөөг бэлтгэх зорилгоор байгууллагын 1 болон 3 дугаар давхрыг ашиглах нөхцөл шаардлага үүсч өрөөнүүдийн зохион байгуулалтыг хийж, яамны өрөөний засвар, цайны өрөөний тохижилт, албан хаагчдын ажлын ширээ, нэмэлтээр тавилга хэрэгслийг авч шинэчлэл хийсэн.</p> <p>Хавсралт нийт : 30 Файл : 6 Зураг : 24</p>	100%
6	6. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	<p>Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/129 дүгээр тушаалд заасан хөтөлбөрийн дагуу яамны албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулахаар Улсын 2 дугаар төв эмнэлэгтэй "урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах тухай" гэрээ байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр яамны нийт 68 албан хаагчийг 6-7 төрлийн шинжилгээнд хамруулсан. /Шинжилгээний төрөл: цус, шээсний шинжилгээ, цээжний хөндийн зураг, ходоодны дуран, хелико бактерийн шинжилгээ г.м/</p>	100%

7	7. Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	<p>1.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн зардал-19.850.000 /Төрийн нарийн бигчийн даргын 2022 оны А124 дүгээр тушаал/ 2.Түлээ, нүүрсний хөнгөлөлт олгох зардал-2.400.000 /Төрийн нарийн бигчийн даргын 2022 оны А131 дүгээр тушаал/ 3.Нийт албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн мөнгөн тусламжийн зардал 49,000,000 төгрөг /Төрийн нарийн бигчийн даргын 2022 оны А153 дугаар тушаал/ 4.Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд 1 албан хаагчид орон сууцны нөхцөл сайжруулахад нь зориулж нэг удаагийн мөнгөн тусламж олгосон зардал 10,000,000 төгрөг /Төрийн нарийн бигчийн даргын 2022 оны А154 дүгээр тушаал/ 5.Удаан хугацаагаар эмчилгээ хийлгэж буй албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу нэг сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон зардал 995,822 төгрөг /Төрийн нарийн бигчийн даргын 2022 оны Б122 дугаар тушаал/ 6.Ар гэрийн гачигдал гарсан 4 албан хаагчид мөнгөн тусламж олгосон зардал 1,000,000 төгрөг /Төрийн нарийн бигчийн даргын 2022 оны Б134, Б151, Б82, Б83 дугаар тушаалууд/ 7.Шинээр гэр хүүхэдтэй болсон албан хаагчид нэг удаагийн мөнгөн тусламж олгосон зардал 300,000 төгрөг /Төрийн нарийн бигчийн даргын 2022 оны Б114 дүгээр тушаал/ Хавсралт : 1 файл</p>	100%
Хэрэгжилтийн дундаж хувь			100%

Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайдын
2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн
02/423 дугаар албан бичгийн хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ СУРГАЛТ, НИЙГМИЙН
БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2023 оны 2 сарын 28-ны өдөр

№

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын үйл ажиллагааны дахь Цахим хөгжил, харилцаа холбооны яамны “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

“Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн 2022 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Тус яамны “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-т тусгасан 7 үйл ажиллагааны хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үзэхэд бүгд бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн болно.

Хэдийгээр сургалт нийгмийн баталгааны хөтөлбөрийг 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр баталсан боловч тус яам байгуулагдсан цагаасаа хойш албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах ажлыг үе шаттайгаар зохион байгуулсан байна:

1.Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалтын үйл ажиллагааны хүрээнд тус яамны Төрийн захиргааны удирдлагын газраас 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд Удирдлагын академиас зохион байгуулсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах танхимын сургалтад яамны бүх албан хаагчдыг хамруулах ажил зохион байгуулсан. Мөн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Архивын ерөнхий газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ц.Золжаргал тус байгууллагад хүрэлцэн ирж “Албан бичгийн стандарт, боловсруулах арга зүй” сэдвээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, сургалт өгсөн. Тус сургалтаар яамны 45 албан хаагчийг хамруулсан.

Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Үндэсний аудитын газартай хамтран “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн талаар яамны болон харьяа, салбар байгууллагуудын шилэн дансны мэдээлэл оруулах үүрэг бүхий албан хаагчдад

сургалт хийв. Мөн 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Салбарын харьяа 8 байгууллагын 14 санхүүгийн ажилтнуудад Сангийн яам, Үндэсний аудитын газар, ТӨБЗГ-ын төлөөлөл, багш нараар Төрийн аудитын хууль тогтоомж, Засгийн газрын нэгтгэсэн тайлан бүртгэл, Төрийн өмчийн хөрөнгийн тооллого, хөдөлгөөний талаар сургалтад хамруулсан.

Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газрын албан хаагчидтай хамтран “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай” танин мэдэхүйн мэдлэг, мэдээлэл өгөх сургалт зохион байгуулсан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Эрсдэлд суурилсан дотоод аудит” сургалтыг Санхүү эдийн засгийн их сургуультай хамтран салбарын хэмжээний байгууллагуудын дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ, нягтлан бодогч нийт 24 албан хаагчдыг хамруулсан.

2.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалтын үйл ажиллагааны хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас яамны албан хаагчдад “Кибер аюулгүй байдлын суурь ойлголт болон нийтлэг тохиолддог халдлагаас өөрийгөө хэрхэн хамгаалах, зөрчилд үзүүлэх хариу арга хэмжээний талаар” мэдлэг ойлголт өгөх танхимын сургалтыг зохион байгуулсан.

3.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хүрээнд байгууллагын захиалгаар 6 хүртэл сарын хугацаатайгаар гадаадын сургуульд мэргэжил дээшлүүлэх зорилгоор суралцсан 2 албан хаагчид суралцах хугацаанд ажлаас чөлөөлж мөн хугацааны цалинг тооцож олгосон. Зайнаас болон цахим хэлбэрээр ажиллах хүсэлт гаргасан 1 албан хаагчтай 6 сарын хугацаатай гэрээ байгуулан цахим хэлбэрээр ажиллуулж, цалин хөлсийг тооцож олгосон. Удирдлагын академийн мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдыг ажлын цагаас чөлөөлж, цалин хөлсийг тооцож олгосон. Албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхыг сайжруулах зорилгоор тус яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын албан хаагчдыг “Бодлого тодорхойлох, судалгаа, стандарт” сэдэвт сургалтад хамруулсан. Төрийн нарийн бичгийн даргын А106 дугаар тушаалаар 5,500,000 төгрөгийн зардлаар зохион байгуулсан.

4.Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд албан хаагчдын ажлын өрөөг бэлтгэх зорилгоор байгууллагын 1 болон 3 дугаар давхрын өрөөнүүдийн засвар, цайны өрөөний тохижилт, албан хаагчдын ажлын ширээ, нэмэлтээр тавилга хэрэгслийг авч шинэчлэл хийсэн.

5.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд Улсын 2 дугаар төв эмнэлэгтэй “урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах тухай” гэрээ байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр яамны нийт 68 албан хаагчийг 6-7 төрлийн шинжилгээнд хамруулсан гэх зэрэг олон арга хэмжээг богино хугацаанд хийж гүйцэтгэсэн амжилттай ажилласан байна.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс үзэхэд тодорхой үр дүнд хүрсэн буюу хангалттай биелсэн гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл ажилчдаас авсан ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаагаар 80 хувьтай үзүүлэлт гарсан бөгөөд барилгын сан техникийн асуудлын улмаас дулааныг

шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаа учир өвлийн улиралд хүйтэн гэдэг шалтгааныг сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээний үлдэх хувь эзэлж байна.

Мөн Бодлого, төлөвлөлтийн газраас “Жендэрийн тэгш байдлыг хангах, ойлголт” сэдэвт сургалт, “Стресс менежмент” сэдэвт сургалтыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулахад албан хаагчдын стрессийн түвшин харьцангуй бага буюу ажиллах нөхцөл шаардлага, ажлын орчин хэвийн тайван гэж үзэж байна.

Иймд үнэлгээ хийгдсэн үйл ажиллагааны дунджаас үзвэл хэрэгжилт 100% буюу Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр батлах тухай” А/129 дүгээр тушаалын хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн гэж үзлээ.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар тодорхой төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж, цаашид үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Яамны Төрийн захиргааны удирдлагын газарт:

1. Яамны “Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг батлуулахдаа дараах үйл ажиллагааны хүрээнд төлөвлөж, хүрэх түвшин, хүрсэн түвшинг тодорхой илэрхийлэх. Цаашид дараах чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр байна. Үүнд:

1) Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт

1.1 Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо /Ажлын байран дахь сургалт, Мэргэшүүлэх сургалт, Туршлага солилцох арга хэмжээ, Бусад/

1.2 Хамрагдсан нийт албан хаагчдын тоо / Эмэгтэй албан хаагч, Эрэгтэй албан хаагч, Удирдах албан тушаалтан, Гүйцэтгэх, туслах албан тушаалтан/

1.3 Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь

2) Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт

2.1. Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо

2.2. Хамрагдсан нийт албан хаагчдын тоо / Эмэгтэй албан хаагч, Эрэгтэй албан хаагч, Удирдах албан тушаалтан, Гүйцэтгэх, туслах албан тушаалтан/

2.3. Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь

3) Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн

3.1. Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)

3.2. Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь

4) Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх

4.1. Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь

4.2. Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)

5) Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх

5.1. Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)

6) Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх

6.1. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)

6.2. Албан хаагчдын хамрагдалт

7) Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал гэх мэт үйл ажиллагааны хүрээнд төлөвлөгөө гаргах.

7.1. Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)

2.Мөн 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, тодорхой, ойлгомжтой, эцсийн байдлаар хянагдсан засваргүй тайланг заасан хугацаанд тайлагнаж хэвших;

3.Үр дүнд суурилсан бодит нотолгоонд тулгуурласан тайлан бичиж ирүүлэх;

4.Төсвөөс шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, баримтад тулгуурласан байдлаар гаргаж хэвших;

5.Төлөвлөгөөний зорилт, шалгуур үзүүлэлтийн дагуу бичсэн хэрэгжилтийг нягтлан уншиж, нотлох баримтын хамтаар хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид өгч хэвших;

6.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлантай танилцаж, холбогдох баримт материалыг судлан үзэх, үнэлгээ хийх, сайдын зөвлөлийн хуралд танилцуулах зэрэг боломжит хугацааг анхаарч тайлагнаж хэвших;

7.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Дээрх зөвлөмжийг хүлээн авч хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажил хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэрхэн ахиулах, ирэх онд хэрхэн зөв төлөвлөх талаар тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР